



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/118

Арвайхээр сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зудын гамшигтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Аймгийн хэмжээнд ихэнх нутгаар цас их орсон, цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал бий болсонтой холбогдуулан сум, орон нутгийг хамруулсан соёл урлаг, спортын тэмцээн уралдааныг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай.

3.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Г.Чимэддагва), Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Шуурхай штабын дарга (Ц.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0245